



ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ХЯНАЛТ,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 08 сарын 15 өдөр

Дугаар А/167

Улаанбаатар хот

Тусгай зөвшөөрөл шинээр олгох, хугацаа
сунгах, төсөл дэмжигдсэн байгууллагад ажлын
байранд үнэлгээ хийх шинжээчдийн баг томилох тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1, 7.1.10, 8 дугаар зүйлийн 8.3.1, 8.4, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, 10.1.2, 10.1.5, 15 дугаар зүйлийн 15.12.2, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3.2, 19.3.4, 19.18, 19.20.2, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1, Эрүүл мэндийн сайдын 2021 оны "Журам шинэчлэн батлах тухай" А/400 дугаар тушаалын 6 дугаар зүйлийн 6.1.1 заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр олгох байгууллагын нэрсийг нэгдүгээр, тусгай зөвшөөрлийн хугацаа сунгах байгууллагын нэрийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Лиценз, зөвшөөрлийн зохицуулалтын газар (Т.Мөнхтуул), Чанарын хяналтын газар (Г.Номин)-т тус тус үүрэг болгосугай.

ДАРГА




Д.НАРАНТУЯА

1422 010167

Эм, эмнэлгийн хэрэгсэлийн хяналт, зохицуулалтын
газрын даргын 2022 оны 08 дугаар сарын 15-ны
өдрийн 11 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт


167



ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ШИНЭЭР ОЛГОХ БАЙГУУЛЛАГЫН НЭР

№	Байгууллагын нэр /РД/	Үйл ажиллагааны чиглэл	Хаяг байршил	Хүчинтэй хугацаа
Нэг. Тусгай зөвшөөрөл шинээр олгох байгууллага				
1	Глобал проспек ХХК РД6840361 9011837565	Биологийн идэвхт бүтээгдэхүүн импортлох, ханган нийлүүлэх	ХУД, 11-р хороо, 3-р хэсэг, Сүүл роял каунти, 311, 403 тоот	2025.08.05
2	Эйн эйн гүмүда велнесс ХХК РД6836194 9011837263	Биологийн идэвхт бүтээгдэхүүн импортлох, ханган нийлүүлэх	БГД, 14-р хороо, 4-р хороолол, Энэбишийн өргөн чөлөө гудамж, 8 тоот	2025.08.05
3	Эс эй эм эй ХХК РД6524028 9021070600	Биологийн идэвхт бүтээгдэхүүн импортлох, ханган нийлүүлэх	СБД, 11-р хороо, 100 айл, Алтаншагай ХХК-ийн байр	2025.08.05

Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын
газрын даргын 2022 оны 08 дугаар сарын 15-ны
өдрийн 17/дугаар тушаалын хоёрдугаар хавсралт
161



ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ХУГАЦАА СУНГАХ
БАЙГУУЛЛАГЫН НЭРС

№	Байгууллагын нэр /РД/	Үйл ажиллагааны чиглэл	Хаяг байршил	Хүчинтэй хугацаа
Хоёр. Тусгай зөвшөөрлийн хугацаа сунгах байгууллага				
1	Монгол фарм ХХК РД5236371 9011157013	Эм, эмнэлгийн хэрэгсэл, биологийн идэвхт бүтээгдэхүүн, оношлуур импортлох, ханган нийлүүлэх	ЧД, 3-р хороо, 40, 50 мянгат, 15172 жуулчны гудамж, 42/201 тоот	2027.09.02